



ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
Х-Р ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 03

Зуунмод

“Газрын харилцааны талаар 2018 онд хийсэн ажлын чиглэлийн хэрэгжилт, 2019 онд хийх ажлын чиглэлийн тухай аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, тэдгээрт Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн газрын харилцааны талаар 2018 онд хийх ажлын чиглэлд тусгагдсан газрыг зүй зохистой, оновчтой бүрэн ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зорилт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлыг “Газрын тухай” болон холбогдох бусад хууль тогтоомж, аймгийн “Газрын талаар 2017-2020 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө”-нд нийцүүлэн зохион байгуулж, зохих үр дүнд хүрч ажилласан байна.

Тухайлбал, аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлын даалгаврыг боловсруулан, аймгийн Засаг дарга, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга нараар батлуулан, журмын дагуу гүйцэтгэгчээр “Лапланд Эко” ХХК-ийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан төлөвлөгөөний төслийг хийлгэжээ.

Сумдын 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшиг эрхийн дуудлага худалдааг газрын Цахим биржээр зохион байгуулж, сумдад “Харицлагатай газрын харилцаа” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, хөдөө аж ахуйн зориулалттай 471.3 мянган га газрыг 704 байршилд, хот суурингийн 3.1 мянган га газрыг 11643 байршилд эзэмшил, өмчлөлийн хэлбэрээр олгож, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр нэгтгэн, хийсэн ажлуудаа байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбаар иргэдэд сурталчилж ажилласан байна. Төлөвлөгөөт онд аймгийн хэмжээнд 9431 иргэнд 1701.29 га газрыг өмчлүүлж, осссон дүнгээр 64230 иргэн газар өмчилж авсны 48807 нь буюу 76.0 хувь нь аймгийн харьят иргэд бөгөөд энэ нь нийт иргэдийн 51.4 хувьд хүрсэн байна.

Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” программын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай хамтран Мөнгөнморьт, Баяндэлгэр, Эрдэнэ, Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Жаргалант сумдад ажиллан хяналт хийн, програмын үйл ажиллагааг төстлэн шалгаж хурд багатай, гацалт ихтэй байгааг тогтоон дүгнэлт гаргаж, бүх сумдын газрын мэдээллийн сангийн ДАТА баазыг аймгийн төвийн Төв серверт хандаж ажиллах технологийн шинэчлэл хийснээр програм хангамжийн үйл ажиллагаа хэвийн доголдолгүй ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.

0100003

Сумдын газрын даамлуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор тэднийг чадваржуулах сургалтыг 3 удаа зохион байгуулсны зэрэгцээ скайнер, принтер, GPS зэрэг тоног төхөөрөмжөөр хангаж ажилласан байна.

Төрийн болон нутгийн удирдлагын байгууллага, орон нутгийн өмчтэй хуулийн этгээдүүдийн эзэмшиж буй газрын судалгааг нягтлан гаргаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулснаар 676 нэгж талбарын 1096.8 га газрыг кадастрын мэдээллийн санд бүртгэсэн байна.

Сумын Засаг дарга нарын газрын харилцааны чиглэлээр гаргасан захирамжуудыг татан авч Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцэж байгаа эсэхийг нягтлан үзэж, алдаа дутагдлыг залруулах, хууль зөрчсөн захирамжуудыг хүчингүй болгох талаар сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, газрын даамлуудад албан бичгээр мэдэгдэж, 232 иргэн, хуулийн этгээдэд 2586,3 га газрыг хууль тогтоомж зөрчин эзэмшүүлсэн 8 сумын Засаг даргын захирамжийг хүчингүй болгуулсан байна.

“Хаягжуулалтын тухай” хуулийг хэрэгжүүлж Өндөрширээт sumaас бусад 26 сум нийт 8399 нэгж талбарын хаягийг газрын мэдээллийн санд шинээр бүртгэж баталгаажуулсан байна.

Газрын төлбөрийн орлогын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг улирал бүр хэлэлцэн дүгнэлт өгч, “Татварын орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх, татварын өрийг барагдуулах” аяны хүрээнд тодорхой ажил зохион байгуулсны дүнд 73 хувиар давуулан биелүүлж, аймгийн төсөвт 2569.6 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Засгийн газрын “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 2018 оны 182 дугаар тогтоолыг хэрэгжүүлж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 10 дугаар хуралдаанаар “Газрын төлбөр”-ийн хэмжээг шинэчлэн тогтоож батлуулсан нь газрын төлбөрийг бүрэн ногдуулж аймгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон байна.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлж дүгнэх ажлыг хэрэгжүүлж сумдын Засаг дарга, газрын даамлуудад энэ талаарх дадлага сургалтыг 2 удаа хийж, зөвлөмж, чиглэл, арга зүйгээр ханган 25 суманд бэлчээрийн газрыг фото мониторингийн аргаар үнэлж дүгнэх 259 цэг байгуулан ажилласан байна.

Бэлчээрийн хортон мэрэгч ихээр тархсан Баян-Өнжүүл, Баянцагаан зэрэг 7 суманд орон нутгийн төсвөөс 35,8 сая төгрөг зарцуулж 11.5 мянган га талбайд тэмцэх ажлыг хийжээ. Мөн Алтанбулаг, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Сэргэлэн, Цээл сумдад улсын төсвийн хөрөнгөөр 50.0 мянган га талбайд бэлчээрийн мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулж, нийт дүнгээр 117.9 мянган га талбайд бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан “Нөхөн сэргээлт хүлээж авах ажлын хэсэг” Алтанбулаг, Баянцагаан, Заамар, Сэргэлэн, Баян сумдад ажиллаж хэмжилт зураглал хийн, стандарт шаардлага хангасан биологийн нөхөн сэргээлт хийсэн 273.32 га, техникийн нөхөн сэргээлт хийсэн 400.57 га талбайг хүлээн авч мэдээллийн санд оруулсанаар 2018 оны эцсийн байдлаар өссөн дүнгээр техникийн нөхөн сэргээлтийг 5585.33 га, биологийн нөхөн сэргээлтийг 3131.32 га талбайд хийгээд байна.

Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн аймгийн газрын харилцааны талаар 2019 онд хийх ажлын чиглэлд аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж эхлэх, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг боловсруулах, сумдын 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж дүнг улирал бүр нийтэд мэдээлж байх, Сумын төв, суурин газрын тэг гортигийг шинэчлэн тогтоож иргэдэд өмчлүүлэх нөөц газрын байршилыг тодорхойлон хамгаалалтад авах, хэсэгчилсэн төлөвлөлтийг хийж, иргэдэд газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлэх, Газар нутгийн нэрийн зургийг тоон хэлбэрт оруулан мэдээллийн сан байгуулж, газар зүйн нэрийг зөв нэрлэн хэвшүүлж, олон нийтэд сургалчилан таниулах, “Газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 03 дугаар тогтооолыг хэрэгжүүлж, газар эзэмшигч, ашиглагч иргэн хуулийн этгээдийн гэрээг шинэчлэн газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн хийж хураан барагдуулах зэрэг газрын харилцааны талаар хийх зайлшгүй шаардлагатай ажлууд тусгагдсан байна.

Газрын харилцааны талаар өмнөх онуудад хийсэн ажлын үр дүнг бататгаж, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах, шаардлагатайг тэмдэглээд, “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18 дугаар зүйл 18.1.2-ын “з”, 19 дүгээр зүйлийн 19.1, “Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.“Аймгийн газрын харилцааны талаар 2018 онд хийх ажлын чиглэл”-ийн зорилт, арга хэмжээг 88.6 хувийн биелэлттэй байх тул “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2.“Аймгийн газрын харилцааны талаар 2019 онд хийх ажлын чиглэл”-ийг хавсралтын ёсоор баталсугай.


3.Энэ тогтоолын 2 дугаар заалтаар батлагдсан “Аймгийн газрын харилцааны талаар 2019 онд хийх ажлын чиглэл”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийн явцад хяналт үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах, газрын харилцааны талаар цаашид хийх ажлыг “Аймгийн газар зохион байгуулалтын шинэ төлөвлөгөө”-нд нийцүүлэн боловсруулж, батлуулахыг аймгийн Засаг дарга /Ж.Батжаргал/-д даалгасугай.

4.Энэ тогтоолыг өөрийн суманд хэрэгжүүлж, хэрэгжилтийн байдалд хяналт үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

5.Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.



Аймгийн Иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын
2019 оны 03 дугаар сарын 12-ны одрийн 12-р
хуралдааны 03 дугаар тогтоолын хавсралт



“ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР 2019 ОНД ХИЙХ АЖЛЫН ЧИГЛЭЛ”

Нийтлэг үндэслэл :

Аймгаас газрын талаар 2017-2020 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг удирдлага болгон “Газрын харилцааны талаар 2019 онд хийх ажлын чиглэл”-ийг боловсруулав. “Газрын харилцааны талаар 2019 онд хийх ажлын чиглэл”-ийг батлан хэрэгжүүлсэнээр аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх Газрын менежментийг сайжруулж, төлөвлөлтийг газрын суурь судалгааны үндсэн дээр иргэд, аж ахуйн нэгжийн саналд тулгуурлан, аймаг, сумдын эдийн засгийн хөгжилд түлхэц өгч, үр ашигтай, өгөөжтэй байхаар хийж, хэрэгжилтэд нь тавих хяналт үнэлгээг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор гүйцэтгэж, биелэлтийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлдг болох зорилт хангагдна. Төв аймгийн 2019 онд газрын харилцааны талаар баримтлах чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Суурь түвшин | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага |
|--|--|---|--|--|--|----------------|--|
| Газар зохион байгуулалтын талаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ: | | | | | | | |
| 1 | Мэдлэгт сууриссан газар зохион байгуулалтын төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор ил тод хийж, тэдгээрийг орон нутагтаа баялаг бүтгэх боломжийг бүрдүүлэн, олон төрөлтөт эдийн засгийн хөгжлийн үндсийг бий болгоно | 1. Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, баглуулан мордож ажиллана. 2. Газар ашиглалтын зориулалт бүрээр газрын тохиромжтой байдлын болон хэрэгцээт байдлын үнээгээний үр дүнд сууриссан Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг боловсруулах, энэ ажлын зардлыг Байгалийн нооц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 18.1-д заасан байгалийн нооц ашигласны төлбөрийн орлогос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах мөнгөноос санхүүжүүлнэ. | ГЗБЕТ-ний гүйцэтгэгч компанийг шалгаруулсан. | Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг ИТХ-аар батлагдсан байна | Үндэслэл, тооцоолол бүхий Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөө батлагдаж, хэрэгжих эхэлсэн байна. | 4 сар | ХОХБТХэлтэс, ГХБХБГазар |
| 2 | Газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу иргэн хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ёмчлүүлэх, ашиглуулах, хамгаалах ажлыг зохион байгуулан газрын харилцаанд шинэчлэл | 3. Сумын тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг тухайн оны 09 сарын 01-нээс ажлын хэсэг байгуулан зохион байтуулж сумдын ИТХ-аар 12 сарын 20 -ны дотор оргөн барьж баглуулан Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангах болдого баримтлана | 27 сум ИТХ-аар батлуулан ирүүлсэн. | Боловсруулж баттуулсан Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилтээр | Сумдын “Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөлт”-ийг нэгж талбар бүрээр төлөвлөж, цахимаар нийтэд ил тод мэдээлэн, газар олголт түүний дагуу хийгдсэн байна. | 3, 4-р улиралд | ГХБХБГазар, Сумын Засаг дарга, Газрын даамал |

| | | | | | | | |
|---|--|---|--|--|---|-------------|--------------------------------|
| | | <p>4. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж үр дунг үнэлэх, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх төсөв санхүү, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэн.</p> <p>5. Газрын биржийн цахим системийг ашиглан газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.</p> | | <p>Сумын тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах хэрэгжүүлэх ажлын чанар үр дунгээр</p> <p>Засгийн газрын 2016 оны 10 тогтоолоор батлагдсан дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулах журамд нийцсэн байна.</p> | <p>Сумын тухай жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөө бүрэн хэрэгжиж, төлөвлөгөөний бүтэц, зохион байгуулалтын уялдаа холбоо сайжирна.</p> <p>Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт олон нийтэд нээлттэй, ил тод, түргэн шуурхай явагдна.</p> | 2-р улиралд | ГХБХБГазар Сумын газрын даамал |
| 3 | Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн нийт иргэн бүрт газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэн. | <p>6. Сумын төв, суурин газрын тэг гортигийг шинэчлэн тогтоож иргэдэд өмчлүүлэх нөөц газрын байршилыг тодорхойлон хамгаалалтад авч, хэсэгчилсэн төлөвлөлтийг хийж, иргэдэд газар өмчлүүлнэ.</p> | <p>Аймгийн хэмжээнд 62039 иргэн газар өмчилсөн.</p> | <p>Газар өмчилсөн иргэдийн тоо, хувь</p> | <p>2019 онд 10330 иргэнд 1607,81 га газрыг өмчлүүлнэ.</p> | Жилдээ | |
| Газрын кадастр, геодези зураг зүйн талаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ: | | | | | | | |
| 4 | Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулах, Лэнд менежер програм хангамжийг хөгжүүлэх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна | <p>7. Газрын нэгдмэл сангийн тайланг сумын Засаг дарга тухайн оны 12 сарын 01-ний байдлаар тасалбар болгон 12 сарын 15 –ны дотор сумын ИТХ-аар баталгаажуулан ГХБХБГазарт хүлээлгэн өгч хэвших ажлыг зохион байгуулна.</p> | <p>2018 онд 11 сум сумын ИТХ-аар баталгаажуулсан</p> | <p>. Засгийн газрын 2003 оны 28-р тогтоолын 2-р хавсаралт “Газын нэгдмэл сангийн тайлан гаргах журамд нийцсэн байна.</p> | <p>Бүх сумдын ИТХ-аар баталгаажуулж ирүүлсэн байна.</p> | 12 сард | ГХБХБГазар, сумын ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|--|---|-----------------|---|
| | | 8. Эрдэнэ, Сэргэлэн, Борнуур, Батсүмбэр, Жаргалант, Сүмбэр сумдын Газрын кадастрын мэдээллийн санг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх нөхөн бүрдүүлэлт хийнэ. | 21 сумын 65 мянган нэгж талбарыг Лэндменежер программд бүртгэж баталгаажуулсан | Нөхөн бүрдүүлэлт хийгдсэн нэгж талбарын тоогоор | Газрын кадастрын мэдээллийн санг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх нөхөн бүрдүүлэлтийн ажил бүрэн хийгдсэнээр 20345 нэгж талбар Газрын мэдээллийн санд нөхөн бүртгэгдсэн байна. | 1-р улиралд | ГХБХБГазар, Сумдын газрын даамал |
| | | 9. Төрийн болон орон нутгийн омчийн байгуулалтуудын эзэмшил газруудыг байршил, хэмжээг нягтлан үзэж, Лэндменежер программд хангамжид бүрэн бүртгэж баталгаажуулж дуусган. | 27 сумын 676 нэгж талбарыг бүртгэж баталгаажуулсан | Баталгаажуулсан нэгж талбарын тоогоор . | Засгийн газрын 193 дугаар тогтооолоор батлагдсан журмыг хэрэгжилтийг хангасан байна | 1,2-р улиралд | ГХБХБГазар, Сумдын газрын даамал |
| | | 10 Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийн веб хувилбарыг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, | | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | “Лэнд менежер” програм хангамжийг веб хувилбарт шилжүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | жилдээ | |
| 5 | Аймгийн хэмжээнд улсын хөрөнгө оруулалтаар хийгдэж буй геодези, зураг зүйн ажил болон мэргэжлийн байгууллагуудын гүйцэтгэсэн газрын кадастрын зураглалыг шалган хүлээн авч, хамтран ажиллана. | 11. Мэргэжилийн байгууллага, иргэдээс ирүүлсэн инженерийн геодези, зураг зүйн ажлын үр дүнг шалган хүлээн авч, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган хэрэглээнд нэвтрүүлнэ | Аймгийн хэмжээнд 21,8 км Инженерийн шугам сүлжээ, 1243,8 шилэн кабелийн геодези, зураг зүйн ажлын тоон зургийг хүлээн авч мэдээллийн сан үүсгэсэн | Дүрэм, журам, стандартад нийцүүлэн хүлээн авсан ажлын үр дүнгээр /тоогоор/ | Геодезийн хэмжилт алдаагүй болж зураг зүйн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд хариушлагатай болно | жилдээ | ГХБХБГазар, ГЗБГЗГазар, Сумдын газрын даамал, |
| 6 | Төв аймгийн сумдын газар нутгийн газар зүйн нэрийг тодотгон тогтоох, газар зүйн | 12. Газар нутгийн нэрийн зургийг тоон хэлбэрт оруулан мэдээллийн сан байгуулж, газар зүйн нэрийг | Сэргэлэн Алтанбулаг сумд тоон хэлбэрт орсон | Аймгийн хэмжээний Газар нутгийн нэрийн зураг | Баян, Баянжаргалан, Баянцагаан, Баян-өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Эрдэнэсант, | 2,3,4-р улиралд | ГЗБГЗГазар, ГХБХБГазар, Сумдын газрын |

| | | | | | | | | |
|---|---|------------------|--|---|--|---|-------------|--|
| | нэрийг ажлыг байгуулна | баяжуулах зохион | зөв нэрлэж хэвшүүлэх, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна. | | тоон хэлбэрээр хийгднэ . | Өндөрширээт, Лүн, Баянхангай сумдын газар зүйн нэрийн зургийг тоон хэлбэрт бүрэн оруулж мэдээллийн санг баяжуулсан байна. | | даамал, Сумын ЗДТГазар |
| 7 | Хаягжуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэн орон нутгийн хаягжуулалтын ажлыг зохион байгуулна | | 13 .Хаягжуулалтын хууль холбогдох журмын дагуу гудамж талбай, зам, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах, тэмдэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулна. | Алтанбулаг, Аргалант, Баян, Зуунмод, Жаргалант, Цээл, Баянцагаан, Бүрэн сумд 853 гудамж, 4234 хашаа, 96 байшин, 7 байршил заасан тэмдэг тэмдэг тэмдэглэгээ хийсэн | Хаягжуулалтын хууль холбогдох журмын дагуу гудамж талбай, зам, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулсан, тэмдэгжүүлсэн хаяг тоогоор | Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгө хаягжуулалтын хуулийн дагуу хаягтай болно. | жилдээ | ГХБХГазар, Сумдын газрын даамал, Сумын ЗДТГазар |
| | | | 14. Орон нутгийн төсөвт хаягийн тэмдгийг сууринуулах ажлын зардлыг тусгуулна. | 2016-2018 онд 7 сум 63 сая төгрөгийн төсөв батлан хаягжуулалт хийсэн | Шинээр хийгдэх хаягжуулалтын тоогоор | Шинээр хийгдэх хаягжуулалтын төсөв аймгийн хэмжээнд батлагдаж сумдад хуваарилагдсан байна. | 2-р улиралд | ХОХБТХэлтэс, СТСХ, ГХБХГазар, Сумдын газрын даамал, Сумын ЗДТГазар |
| | | | 15. Шинээр байгуулсан суурин, хороолол, гудамж, зам, талбайд нэр, дугаар, хаяг өгч хаягийн зураг зохиож, баталгаажуулах ажлыг зохион байгуулна | 2015 онд 27 сумын хаягийн тогтоол шинэчлэгдэн гарсан | Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 280 тоот тогтооюур батлагдсан “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ын хэрэгжилтээр | Шинээр байгуулагдсан суурин, гэр хороолол тухай шатны ИТХ-аар баталгаажин хаягжилт хийгдсэн байна. | жилдээ | ГХБХГазар, Сумдын газрын даамал, Сумын ЗДТГазар |

Газрын төлбөр үнэлгээний талаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

| | | | | | | | |
|---|---|--|--|--|--|-----------------|--|
| 8 | Газрын төлбөрийн тухай хууль, Татварын тухай хуулийн хэрэгжилтийг ханган газрын төлбөрийн ноогдуулалтыг бүрэн хийж, татварын бааз суурийг нэмэгдүүлэн дутуу төлөлтийг барагдуулах ажлыг зохион байгуулна. | 16. Газрын дуудлага худалдааны анхны үнийг бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна | 2011-2018 он хүртэл 2529.0 сая төгрөг төвлөрсөн байна. | Төсөвт төвлөрүүлсэн төлбөрийн хэмжээгээр | Аймгийн ИТХТ-ын 2012.07.04-ны өдрийн 77 дугаар тогтоолын дагуу 2017.09 сарын байдлаар Аудитын дүгнэлт шинэчлэгдсэн судалгааны дүнгээр тогтоогдсон 5,6 тэрбум төгрөгийн үлдэгдэл 2 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ | жилдээ | ГХБХБГазар, Сумын ЗДТГ |
| | | 17 Газрын төлбөрийн орлогоор 1.700 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлнэ. | | Төсөвт төвлөрүүлсэн төлбөрийн хэмжээгээр | Газрын төлбөрийн орлогын сар улирлын төлөвлөгөөг жигд ханган биелүүлсэн байна./ | жилдээ | ГХБХБГазар, Сумын ЗДТГ |
| | | 18. “Газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Аймгийн ИТХ-ын 2018 оны 03 тоот тогтоолын хүрээнд газрын төлбөрийн ногдуулалтыг хийж газар эзэмшигч ашиглагч иргэн хуулийн этгээдийн гэрээг шинэчлэх ажлыг зохион зохион байгуулан гүйцэтгэлийг цахим хэлбэрт шилжүүлнэ. | | Газрын төлбөрийн ногдуулалт, газар эзэмшигч, ашиглагч иргэн хуулийн этгээдийн гэрээний тоогоор | Газрын төлбөрийн тухай хууль, Аймгийн ИТХ-ын 2018 оны 03 тоот тогтоолын хэрэгжилтийг хангасан байна | 1,2,3-р улиралд | ГХБХБГазар, Сумын Засаг дарга, газрын даамал |
| 9 | Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газруудаас төлбөрийг бүрэн ногдуулж, төвлөрүүлнэ. | 19. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газруудаас Засаг даргын захирамж шийдвэрлгүй, гэрчилгээ, гэрээгүй газруудын судалгааг гарган гэрийлгэжүүлэх, газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн хийх | 89 аж ахуйн нэгж байгууллагтай гэрээ байгуулж 654.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. | Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн байгуулсан гэрээний тоогоор | Аймгийн төсвийн орлого нэмэгдэж. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдэй газар эзэмших гэрээ шинээр байгуулсан байна | 2,3-р улиралд | ГХБХБГазар, Сумын Засаг дарга |

| | | | | | | | |
|----|--|---|---|--|--|-------------|--|
| | | | | | | | |
| 12 | “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана | 23. Холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгай зөвшөөрөл нь цүцлэгдсан газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулж, холбогдох шийдвэрийг аймаг болон төрийн захиргааны байгууллагын мэдээллийн санд бүртгүүлнэ. | Орон нутгийн тусгай хэрэгцээ, хамгаалалтанд нийт 1561833 га газар авсан байна. | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрууд хамгаалагдана. | жилдээ | ХОХБТХ, ГХБХБГ, Сумын Засаг дарга |
| | | 24. “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн дагуу шинэчлэн тогтоогдсон талбайн солбилицуудыг аймгийн мэдээллийн санд бүрэн оруулж, тэмдэгжүүлэн, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлтийг хийлгэж, хяналт тавьж ажиллана.. | Шинэчлэн тогтоогдсон нийт 61808,7 га талбайн солбилицуудыг аймгийн мэдээллийн санд бүрэн оруулж бүртгэсэн. | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт тавигдах хяналт хамгаалалт сайжирч, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ нэмэгдсэн байна. | жилдээ | ГХБХБГ, БОАЖГ Сумын ЗДТГ |
| 13 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой газрыг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусган баталгаажуулна. | 25. Ашигт малтмалын болон Газрын тухай хуулийг хэрэгжүүлж бичил уурхай эрхлэх, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулах газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авна. | Аймгийн хэмжээнд нийт 9 байршилын 24,77 га газрыг бичил уухайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. | Бичил уурхай эрхлэх, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулах газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын хэмжээ байршилын тоогоор | Усан сан бүхий газар болон голын сав газруудад байгаль экологийн эвдрэл хохирол учирдаг байдал буурна. | 3-р улиралд | Эрдэс баялагийн зөвлөл ГХБХБГ, Сумын ЗДТГ |

Уул уурхайн газрын талаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ:

| | | | | | | | |
|----|---|--|---|--|--|--------------------|--|
| 10 | <p>Аймгийн газар нутгийг ой, усны нөөцийн байршил, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төвлөрөл, тархалт, аялал жуулчлалын бүс нутаг болон ашигт малтмалын орд, уурхайн байршил зэргийг харгалзан бүсчилж цаашид геологи хайгуулын ажлыг төрөөс болон орон нутгаас зөвшөөрсөн газарт гүйцэтгүүлнэ.</p> | <p>20. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай “Мэдэгдэл”-д сумын иргэдийн Төлөөлогчдийн хурлаас санал өгөхөд нутгийн иргэдийн оролцоог хангана.</p> | <p>2018 онд тусгай зөвшөөрөл хүссэн 27 мэдэгдлийн хариу хүргүүлсэн</p> | <p>Орон нутгийн иргэдийн оролцоогоор</p> | <p>Нутгийн өөрөө удирдах байгууллагын саналаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдох эсэх асуудлыг шийднэ.</p> | <p>жилдээ</p> | <p>ГХБХБГазар, БОАЖГазар, Сумын ЗДТГ, Газрын даамал,</p> |
| 11 | <p>Байгаль орчинд зэлтэй дэвшилтэй техник технологи бүхий уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжин хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.</p> | <p>21. Өмнөх онуудад стандарт шаардлага хангаж биологийн нохон сэргээлт хийгдсэн газруудын чанар байдлыг мэргэжлийн байгууллагаар дүгнүүлж, зохих журмын дагуу бэлчээрийн газрын ангилалд шилжүүлэх ажлыг зохион байгуулана.</p> | <p>Бэлчээрт шилжүүлсэн талбайн хэмжээгэр</p> | <p>Бэлчээрт шилжүүлсэн талбайн хэмжээгэр</p> | <p>Бэлчээрийн газрын хэмжээ нэмэгдэж, мэдээллийн сан баяжигдан, Газрын сангийн тайланд тусгагдсан байна.</p> | <p>4-р улиралд</p> | <p>Аймгийн ЗДТГазар, ГХБХБГазар, БОАЖГазар, Сумын ЗДТГ</p> |
| | | <p>22. Төрөөс болон аймагаас баримталж буй бодлогод нийцсэн, эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий уул уурхайн төслүүдийг дэмжиж ажиллана.</p> | <p>Ашигт малтмалын зориулалтаар 2, Түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар 3 хайгуулын тусгай зөвшөөрөл 2018 онд олгосон байна.</p> | <p>Дэмжигдсэн төслийн тоогоор</p> | <p>Аймгийн бодлоготой нийцсэн төслүүд дэмжигднэ.</p> | <p>жилдээ</p> | <p>ХОХБТХ, БОАЖГ, МХГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ</p> |

Хот сууринийн газрын талаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ:

| | | | | | | | |
|----|---|---|--|---|---|------------|--|
| 14 | Хот суурингийн ангиллын газрыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан зүй зохицой эзэмшүүлж, ашиглуулах, хамгаалах ажлыг зохион байгуулна. | 26. Хот байгуулалтын мэдээллийн сан байгуулж, одоо байгаа болон шинээр ашиглалтад орж байгаа барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийг оруулан баяжилт хийж хөтлөх | Мэдээллийн сан байгуулагдсан. | Орсон барилга байгууламж, шугам сүлжээний тоогоор | Хот байгуулалтын мэдээллийн сангийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. | жилдээ | ГХБХБГ, Сумдын ЗДТГ |
| | | 27. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан сумдад “Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 4 жилийн хугацаатайгаар боловсруулж хэрэгжүүлнэ | 20 сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний тоо, түүний хэргэжилтээр | 5-аас доошгүй сумын төлөвлөгөөг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулсан байна. | 3-р улирал | ГХБХБГ, Сумдын ЗДТ |
| | | 28. Зуунмод хотын хуучин барилга орон суушнуудад дахин төлөвлөлт хийх замаар шинэ хороолол байгуулах ажлыг хувийн хэвшлийн оролцоотой эхлүүлнэ. | 1 байршилд гүйцэтгэгч шалгарсан. | Бүтээн байгуулалтын ажлын явцаар | Зуунмод хотын 1,2,34,35,36-байрны орчим 1,3 га орон сууцны хороолол байгуулагдаж эхэлсэн байна. БАМ-ын байрны орчмын дахин төлөвлөлтийн төсөл зарлагдаж, гүйцэтгэгч шалгарсан байна. | 2-р улирал | ГХБХБГазар, ХОХБТХэлтэс, Зуунмод сумын ЗДТГ, Газрын даамал |
| 15 | Сумдын хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр баригдах барилга байгууламжийн газрын асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэнэ | 29. Шинээр баригдах барилга байгууламжийн газрын асуудлыг тухайн сумын газар зохион байгуулалтын төлөвлөлөгөөнд тусган шуурхай шийдвэрлүүлж, орон нутгийн замын оновчтой сүлжээ тогтоон батлуулж мөрдлөг болгоно. | Хөрөнгө оруулалт батлагдсан. | Газар баригдах байгуулалтын төлөвлөгөөнийн хэрэгжилтээр | Шинээр баригдах Багийн зориулалтаар 2 барилга, Цэцэрлэг 3, Сургуулийн дотуур байр 7, Сургуулийн зориулалтай 4, спорт заал1 | жилдээ | ГХБХБГазар Сумын ЗДТГ, Газрын даамал, НВХэлтэс |

| Бэлчээрийн газрын талаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ: | | | | | | | |
|---|---|--|--|------------------------------------|--|-------------|---|
| | | | | | | | |
| 16 | Хөдөө аж ахуйн эрүүл бүсийн газрыг сум бүрт тогтоож орон нутгийн тусгай хэрэгцээнд авна. | 30. Эдийн засгийн ач холбогдол бүхий хөдөө аж ахуйн эрүүл бүс тогтоох боломж, үндэслэлийг судлан үзсний үндсэн дээр боломжтой сумдад уг бүсийг тогтоон орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, төмөр зам болон авто зам бүхий дэд бүтэц сайтай газар тариалан илүү хөгжсөн сумдад эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх газрын асуудлыг шийдвэрлэн. | Эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар аймгийн тусгай хэрэгцээнд 187999,8 га газар авсан байна. | Олгосон газрын хэмжээгээр /га-аар/ | Сумын тусгай хэрэгцээний газрын хэмжээ нэмэгдсэн байна. гүйцэтгэлээр | жилдээ | ХОХБТХ ГХБХБГ, ХХААГ, Сумдын ИТХ, ЗДТГазар |
| | | 31. Сум бүрийн эрчимжсэн болон суурин мал аж ахуй эрхлэх бүс нутгийн хил хязгаар, хэмжээг шинэчлэн тогтоож, нэг хонин толгойд шилжүүлсэн элит малд 0,2 га хүртэлх ногдохоор тооцсон бэлчээр, таримал тэжээлийн талбайг уг мал аж ахуйг эрхлэгчдэд гэрээгээр эзэмшигүүлнэ. | Баянчандмань сум 284 га газрыг эрчимжсэн болон суурин мал аж ахуй эрхлэгч иргэдэд хувиарласан | Олгосон газрын хэмжээгээр /га-аар/ | эрчимжсэн болон суурин мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна. | 2-р улиралд | ХОХБТХэлтэс ГХБХБГ, ХХААГ, Сумдын ИТХ, ЗДТГазар |
| 17 | Бэлчээрийн төлөв байдал, чанаарын улсын хянан баталгааг журмын дагуу хийж түүнийг үндэслэн бэлчээрийн даацаад тохируулан оновчтой ашиглах, хамгаалах асуудлыг хэрэгжүүлнэ | 32Бэлчээрийн газрын фото аргаар мониторингийн үнэлж дүгнэн. | 2018 онд 25 суманд хийсэн | Зураглал гаргаж баримталж ажиллана | Бэлчээрийн менежмент сайжирна | 3-р улиралд | ХОХБТХ ГХБХБГ, ХХААГ, Сумдын ИТХ, ЗДТГазар |
| | | 33. Бэлчээрийн хортон мэрэгчид нэрвэгдсэн талбайн байршлыг тодорхойлон зураглалыг гарган, устгалын ажлыг хийлгэнэ. | 1201987,1 га газрын зураглалыг гаргасан. 95163,3 га бэлчээрийн газарт хамгаалах арга хэмжээ авсан. | Устгал хийсэн талбайн хэмжээгээр | Бэлчээрийн талбайг хамгаалсан байна | 2,3 улиралд | ХОХБТХ ГХБХБГ, ХХААГ, Сумдын ИТХ, ЗДТГазар |

Тариалангийн газрын талаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ:

| | | | | | | | |
|----|---|---|---|--|--|--------|--|
| 18 | Тариалангийн бүс нутагт “Тариалангийн тухай” хуулийг хэрэгжүүлэн хамгаалах арга хэмжээг зохион байгуулах. | <p>34. Тариалангийн талбай эзэмшигчдийн хөрс хамгаалах агротехнологи хэрэглэх, хашаажкуулах, ойн зуравтай болгох зэрэг хамгаалах арга хэмжээг сумын Засаг дарга, газрын даамалтай байгуулах гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.</p> <p>35. Шинээр атар газар хагалуулахгүй байх бодлого баримталж, хагалсан иргэн, аж ахуйн байгууллагад хуулийн дагуу арга хэмжээ тооцно.</p> | <p>30125,1 га тариалангийн талбайд хамгаалах арга хэмжээ авсан.</p> <p>2018 онд Жаргалант суманд 21,9 га атар газар хагалсан 12 иргэнд торгууль ногдуулж шийтгэлийн хуудас өгч 9-н иргэний материалыг бүрдүүлэн прокурорт шилжүүлсэн.</p> | <p>Хамгаалагдсан талбайн хэмжээгээр</p> <p>Зөрчлийн бууралтаар</p> | <p>Тариалангийн талбайн хамгаалалт сайжирч цөлжилтэөс сэргийлнэ</p> <p>Газрын тухай хууль болон Тариалангийн тухай хууль хэрэгжинэ</p> | жилдээ | ГХБХБГ, Сумдын ИТХ, ЗДТГазар |
| | | <p>Монгол улсын Засгийн газрын “Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” 2018 оны 131 дүгээр тогтоолыг, аймгийн газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар батлагдан мөрдөгдөж буй бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх, зохих тооцоо судалгааг хийсний үндсэн дээр мал сүргийг төрөлжүүлэх, эрчимжүүлэх, шаарлагатай тохиолдолд бэлчээр, ус бүхий нутагт шилжүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааг зохион байгуулна.</p> | | <p>Төлөвлөж хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлээр</p> | <p>Малын тоо, бэлчээрийн даацын тооцоо хийгдэж, тодорхой бодлого төлөвлөгдэж, зохих сургалт, сурталчилгаа хийгдсэн байна.</p> | жилдээ | ГХБХБГ, ХХААГ, МХГазар, Сумдын ИТХ, ЗДТГазар |

| Ойн сангийн газрын талаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
|--|---|---|---|--|--|---------------|--|
| 20 | Аймгийн газрын нэгдмэл санд бүртгэлтэй ойн сангийн газрын ойг нөхөн сэргээх, зохицтой ашиглах, хамгаалах ажлыг зохион байгуулна | 36. Мод үржүүлэг, жимс жимсгэний зориулалтаар эзэмшүүлсэн болон ойжуулсан талбайд хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгч шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулан ойн сангийн ангилалд бүртгэж баталгаажуулана. | Лүн суманд 200 га, Баянхангай суманд 2 га нийт 202 га газрыг ойн сангийн ангилалд шилжүүлэхээр мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулсан. | Төлөвлөгөөний хэрэгжилтээр | Ойн сангийн газарт бүрэн бүртгэгдсэн байна. | жилдээ | ХОХБТХ ГХБХБГ, БОАЖГазар, Ойн нөхөрлөлүүд Сумдын ИТХ, ЗДТГазар |
| Усан сангийн газрын талаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 21 | Аймгийн газрын нэгдмэл санд бүртгэлтэй усан сан бүхий газрыг зохицтой ашиглах, хамгаалах ажлыг зохион байгуулна | 37. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, тал хээрийн сумдад бэлчээрийн малын ундны усыг нэмэгдүүлэх хурын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах тохиромжтой байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийгдэж байршилыг тогтооно. | Бонуур, Жаргалант, Баянцогт сумдад 3 хиймэл нуур, Бүрэн суманд 5 цөөрөм байгуулсан | Байгуулагдсан хөв цөөрмийн тоогоор | З-аас доошгүй хөв цөөрөм байгуулагдана | 2,3-р улиралд | ХОХБТХ ГХБХБГ, БОАЖГазар, Сумдын ИТХ, ЗДТГазар |
| Хилийн цэс, тусгай хамгаалалттай газрын талаар хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 22 | Аймгийн тусгай хэрэгцээний болон хамгаалалттай газрын хэмжээг нэмэгдүүлнэ. | 38. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санг баяжуулж, шинээр орон нутгийн тусгай хэрэгцээ, хамгаалалтад авсан газруудыг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулна. | 2018 онд Заамар, Баян, Баянжаргалан сумдын 9 байршилын 24,77 га газрыг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын мэдээллийн санд бүртгүүлсэн. Аймгийн ИТХ-н 2017 оны 5-р хуралдааны 03 тоот тогтооолоор 1561833 га ОНТХХ-тай газрыг бүртгүүлэхээр хүргүүлсэн | Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээгээр | Тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээ нэмэгдэнэ. | жилдээ | ГХБХБГазар, Сумдын газрын даамал, Сумын ЗДТГазар |
| 23 | Нийслэл Улаанбаатартай хил залгаа сумдын болон | 39. Төв аймгийн Улаанбаатар хот болон бусад аймагтай холбоотой хилийн | Монгол улсын ерөнхий сайдын 2018 оны 89 дугаар | Улсын Их хурлаас баталсан зарлиг, тогтоолыг | Хилийн цэсийн маргааныг шийдвэрлэсэн байна. | жилдээ | ГЗБГЗГазар, ГХБХБГазар, Аймгийн |

| | | | | | | | |
|----|--|--|---|---|---|---------------|---|
| | сумд хоорондын хилийн цэсийн маргааныг шийдвэрлэнэ. | цэсийн маргаантай асуудлыг судалж хилийн цэсд өөрчлөлт оруулан, тодотгох санал боловсруулах мэргэжлийн комиссыг байгуулж ажиллуулах талаар Засгийн газарт санал уламжлан уг асуудлыг шийдвэрлүүлэнэ. | захирамжаар БХБ-ны Сайдаар ахлуулсан хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх санал боловсруулах ажлын хэсэг; “Нийслэл, аймаг, сумд хоорондын хилийн цэсийн зөрчил маргааныг хянаж шийдвэрлэх санал боловсруулах” дэд ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байна. | мердөнө | | | ЗДТГ, Сумдын ЗДТГ. |
| | | 40. Сумын хэмжээнд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хилийн цэсийн шугамын гадна талд болон дамнан олгосон зөрчилтэй нэгж талбарын судалгааг нарийвчлан гаргаж шийдвэрлүүлнэ. | Аймгийн хэмжээнд сумд хооронд болон хил дамнасан 2582 нэгж талбар зөрчилтэй байна. | Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилгасан тоогоор зөрчилтэй байна. | ГЭБГЗГазрын даргын А/40 тоог тушаалаар батлагдсан Харья нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна олгосон нэгж талбартуудын зөрчлийн арилгах журам хэрэгжсэн байна | 1-2-р улиралд | ХОХБТХ ГХБХБГ, |
| 24 | Газрын тухай хууль, тогтоомжийг сурталчлан, хэрэгжилтийг ханган зөрчлийг арилгах арга хэмжээ авна. | 41. Сумдаас газар олголтын талаар гарч байгаа захирамж, хурлын шийдвэрүүдийг татан авч дүгнэлт хийж хууль, тогтоомж зөрчсөн эрхийн актыг цуцлах, хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцно | 8 сумын Засаг даргын хууль тогтоомж зөрчин олгосон 232 иргэн, хуулийн этгээдийн 2586,3 га газрыг хүчингүй болгосон. | Хяналт шалгалтын үр дүнгээр | Газрын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна | жилдээ | ГХБХБГазар, МХГазар, |
| | | 42. Газрын харилцааны талаарх багц хуулиудыг иргэн, аж ахуй нэгж байгууллагад сурталчлах | 3 сумын 6 багийн ИХ болон 5 байгууллагын албан хаагчид болон 27 | | | жилдээ | ГХБХБГазар, Сумдын Засаг дарга, газрын даамал |

| | | | | | | | |
|--|--|--|---|---------------------------------------|---|---------------|---------------------------------|
| | | <p>ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллана.</p> | <p>суманд нээлттэй өдөрлөг, ТӨВТВ болон TBS телевизд Газрын тухай багц хуулиуд, ГЗБ-ын тухайн жилийн төлөвлөгөөг иргэдэд сурталчилсан</p> | | | | |
| | | <p>43. Газар ашиглалт, газрын зөрчил маргааны судалгааг нарийвчлан гаргаж, хууль зөрчин олгосон газруудыг цушлах, дахин төлөвлөх зэргээр хуулийн хүрээнд асуудлыг шийдвэрлэнэ.</p> | <p>Газрын мэдээллийн сангийн 533 зөрүүтэй нэгж талбаруудын зөрчил ,685 системийн өөрчлөлтийн алдааны зөрчил , давахцалтай болон дамнасан барилгын 1640 нэгж талбарын зөрчлийг арилгасан</p> | <p>Газрын зорчлийн шийдвэрлэлтээр</p> | <p>Газар ашиглалт, газрын зөрчил маргааны судалгааг нарийвчлан гарч зөрчил арилсан байна.</p> | <p>жилдээ</p> | <p>ГХБХБГазар, МХГазар,</p> |